

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Хот тохижилт” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код:

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он	Аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Утас: 261665 Цахим хаяг: Аудитын менежер: Утас: 261628 Цахим хаяг: Ахлах аудитор: Утас: 261628 Цахим хаяг: Аудитор: Утас: 260512 Цахим хаяг:
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ХАНБОГД СУМЫН "ХОТ
ТОХИЖИЛТ" ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.ЭРХЭМБААТАР ТАНАА

2022.03.15 № 292

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ханбогд сумын "Хот тохижилт" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ханбогд сумын "Хот тохижилт" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Авлага, өглөгийн дансанд он дамжсан эзэн холбогдогч нь тодорхойгүй найдваргүй 264.1 сая төгрөг, урьдчилж орсон орлого 290.6 сая төгрөг, тайлант оны 182.5 сая төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг буруу илэрхийлсэн, үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 27.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 болон санхүүгийн тайлагналын "Ангилал" батламж мэдэгдлийн "ажил гүйлгээ, үйл явдлыг зөв дансанд ангилж бүртгэсэн байх" гэсэнтэй нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон зүйл

Ханбогд сумын "Хот тохижилт" ОНӨААТҮГ нь 2015 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа Ханбогд сумын Тамгын газрын дансанд бүртгэлтэй 3 давхар оффисын барилгыг эд хогшлын хамт ашиглаж ирсэн байна.

Сумын ИТХ-аас "Хот тохижилт" ОНӨААТҮГ-ын ашиглаж буй барилгыг балансаас балансад шилжүүлэн авах санал гаргасан боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Аудитын гол асуудлууд

Санхүүгийн тооцоолох групп-н "LEADER" программыг 2020 оны 3 дугаар сараас ашиглаж байгаа ба уг программ нь санхүүгийн тайлангийн шаардлага хангахгүй тоон мэдээллүүд буруу илэрхийлэгдэж, тайлан буруу гарсан байна.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

213023449

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн өмчит аж ахуйн нэгжийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	219.5	109.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	530.7	823.2
	Нийт хөрөнгийн дүн	1,452.2	1,251.7
	Нийт өр төлбөрийн дүн	1.0	0.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	398.6	454.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	399.5	454.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,681.9	716.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,427.1	858.7
	Үйл ажиллагааны үр дүн	254.8	-142.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	26.1	0.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	228.7	-142.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	698.2	1,002.4
	Тайлант оны үр дүн	304.2	-72.0
	Эцсийн үлдэгдэл	1,002.4	930.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,432.8	829.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,162.5	851.6
	Үйл ажиллагааны ЦМГ	270.3	-22.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-87.8
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	3.5	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	273.5	-110.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54.2	219.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	219.3	109.3
Зорилтот түвшний гүйцэтгэл			
	Нийт орлогын дүн	4,432.7	829.3
	Борлуулалтын орлого	4,428.1	684.3
	Бусад орлого	4.6	144.9
	Нийт зардал	3,427.1	858.7
	ББӨ	3,042.2	630.8
	Захиргаа, удирдлагын зардал	384.9	227.9

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Хот тохижилт” ОНӨААТҮГ нь “Орон нутгийн нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, авто зам, гадаргуугийн болон хөрсний усны зайлуулах, гэрэлтүүлэг, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх нэгдсэн удирдлагаар хангах” гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОНӨААТҮГ юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тооцоолох групп-н “LEADER” программыг 2020 оны 3 дугаар сараас ашиглаж байгаа ба уг программ нь санхүүгийн тайлангийн шаардлага хангахгүй тоон мэдээллүүд буруу илэрхийлэгдэж, тайлан буруу гарсан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Ханбогд сумын “Хот тохижилт” ОНӨААТҮГ нь 2015 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа Ханбогд сумын Тамгын газрын дансанд бүртгэлтэй 3 давхар оффисын барилгыг эд хогшлын хамт ашиглаж ирсэн байна.

Сумын ИТХ-аас “Хот тохижилт” ОНӨААТҮГ-ын ашиглаж буй барилгыг балансаас балансад шилжүүлэн авах санал гаргасан боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Ханбогд сумын “Хот тохижилт” ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5 мэдээллийг ил тод байршуулаагүй, 141.8 сая төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

/Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж/

Аудитаар нийт 1,364.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 453.9 сая төгрөгийн алдааг залруулж, 906.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 4.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 1,222.3 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон түвшнээс 1,214.0 сая төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 453.9 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрдэл дутуу,
- ААНБОАТ-ын 85.8 сая төгрөгийг орлого үр дүнгийн тайлан дахь татварын дараах ашгийн дүнгээс зөрүүтэй илэрхийлсэн
- Даатгуулагчаас төлөх 18.1 мянган төгрөгийн НДШ-ийг Нийгмийн даатгалын байгууллагад төлөх зардлаар буруу илэрхийлсэн.
- Өмнөх онд урьдчилгаа төлбөрийг нь төлж, тайлант онд хүлээн авсан 350.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгөөр бүртгэж, тайлагнасан.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨААТҮГ	1					1		
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1					1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ										
2	ОНӨААТҮГ	11	1222.8	3	453.9			3	764.2	3	4.7
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	11	1222.8	3	453.9			3	764.2	3	4.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ										
2	ОНӨААТҮГ	1	141.8					1	141.8		
	Дүн	1	141.8					1	141.8		
	НИЙТ ДҮН	12	1364.6	3	453.9			4	906.0	3	4.7

